

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багахангай дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/60/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:undarmaam@audit.gov.mn">undarmaam@audit.gov.mn</a> Аудитор: Д.Нарантуяа Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:narantuyad@audit.gov.mn">narantuyad@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 130  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ  
ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА, ТӨСВИЙН  
ШУУД ЗАХИРАГЧ Д.ЭНХТАЙВАН  
ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багахангай дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Багахангай дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 92,475.0 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Санхүүгийн дэмжлэг олгох гэрээний 3 дугаар зүйлийн 3.5 заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2018-2022 онуудад олгосон зээлийн эргэн төлөлтийн 26 иргэний 92,475.0 мянган төгрөгийн барагдуулаагүй.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u><b>337,392,245.20</b></u>	<u><b>387,963,596.20</b></u>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	337,392,245.20	387,963,596.20
33300	Татаас, санхүүжилтийн авлага	23,399,000.00	115,235,351.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	314,193,245.20	272,728,245.20
3351	Байгууллагаас авах авлага	5,485,745.20	5,485,745.20
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	308,507,500.00	267,242,500.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	137,066,000.00	115,382,000.00
33705	Хөгжлин бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	48,829,000.00	56,585,500.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	39,829,500.00	27,760,000.00
33717	Ахмад мэргэжилний зөвлөх үйлчилгээ	25,727,500.00	29,136,000.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	57,055,500.00	38,379,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<u><b>337,392,245.20</b></u>	<u><b>387,963,596.20</b></u>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<u><b>337,392,245.20</b></u>	<u><b>387,963,596.20</b></u>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<u><b>337,392,245.20</b></u>	<u><b>387,963,596.20</b></u>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	337,392,245.20	387,963,596.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	337,392,245.20	387,963,596.20
51210	Өмнөх үеийн үр дүн	337,392,245.20	302,063,245.20
51220	Тайлант үеийн үр дүн		85,900,351.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<u><b>337,392,245.20</b></u>	<u><b>387,963,596.20</b></u>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>312,232,000.00</b>	<b>337,772,000.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>312,232,000.00</b>	<b>337,772,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	312,232,000.00	337,772,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	312,232,000.00	337,772,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>278,910,530.00</b>	<b>251,871,649.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>278,910,530.00</b>	<b>251,871,649.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,514,070.00	34,538,629.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,514,070.00	34,538,629.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,514,070.00	34,538,629.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	274,396,460.00	217,333,020.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	71,718,530.00	63,106,020.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	71,718,530.00	63,106,020.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	109,007,170.00	154,227,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	109,007,170.00	154,227,000.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	93,670,760.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	93,670,760.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>33,321,470.00</b>	<b>85,900,351.00</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>33,321,470.00</b>	<b>85,900,351.00</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>312,232,000.00</b>	<b>337,772,000.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>312,232,000.00</b>	<b>337,772,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	312,232,000.00	337,772,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	312,232,000.00	337,772,000.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>405,474,530.00</b>	<b>497,859,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>405,474,530.00</b>	<b>497,859,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,499,090.00</b>	<b>34,458,129.00</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,499,090.00	34,458,129.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,499,090.00	34,458,129.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>400,975,440.00</b>	<b>463,400,871.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	198,725,740.00	193,858,020.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	198,725,740.00	193,858,020.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	93,242,530.00	109,455,851.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	93,242,530.00	109,455,851.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	109,007,170.00	159,997,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	109,007,170.00	159,997,000.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(93,242,530.00)</u></b>	<b><u>(160,087,000.00)</u></b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	93,242,530.00	160,087,000.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	93,242,530.00	160,087,000.00
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b><u>93,242,530.00</u></b>	<b><u>160,087,000.00</u></b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	0.00	0.00	304,070,775.20	304,070,775.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>304,070,775.20</b>	<b>304,070,775.20</b>
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			33,321,470.00	33,321,470.00
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>337,392,245.20</b>	<b>337,392,245.20</b>
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>337,392,245.20</b>	<b>337,392,245.20</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-35,329,000.00	-35,329,000.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>302,063,245.20</b>	<b>302,063,245.20</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00		0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	85,980,851.00	85,980,851.00
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>388,044,096.20</b>	<b>388,044,096.20</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	337,772,000.00	228,316,149.00	109,455,851.00	67.6
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	337,772,000.00	228,316,149.00	109,455,851.00	67.6
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	47,578,000.00	34,458,129.00	13,119,871.00	72.4
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	47,578,000.00	34,458,129.00	13,119,871.00	72.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,578,000.00	34,458,129.00	13,119,871.00	72.4
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	290,194,000.00	193,858,020.00	96,335,980.00	66.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	290,194,000.00	193,858,020.00	96,335,980.00	66.8
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	338,772,000.00	228,316,149.00	110,455,851.00	67.4
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	337,772,000.00	228,316,149.00	109,455,851.00	67.6
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	337,772,000.00	228,316,149.00	109,455,851.00	67.6
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,000,000.00	-	1,000,000.00	0.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	-	1,000,000.00	0.0

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,311,543.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

### Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд авлагын эхний үлдэгдлийг 800.0 мянган төгрөгөөр дутуу, тайлант оны авлагыг 5,561.0 мянган төгрөгөөр, хуримтлагдсан үр дүнг 6,361.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг 312,232.0 мянган төгрөгөөр зардлын эхний үлдэгдлийг 278,910.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайланд эхний үлдэгдлийг 405,474.5 мянган төгрөгөөр, тайлант оны орлогыг 159,087.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, зардлыг 73,958.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг 634.0 мянган төгрөгөөр, тайлант оны зардлыг 22,398.4 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.
- Мөнгөн хөрөнгийн журналд 46,127.5 мянган төгрөгийн ажлын хөлсийг бөөн дүнгээр бүртгэсэн зэрэг нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, МНС-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 иж бүрэн байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 92,475.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 92,475.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

## 5.2 Албан шаардлага

5.1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2018-2022 онд олгосон зээлийн эргэн төлөлтийн 26 иргэний 92,475.0 мянган төгрөгийг барагдуулаагүй, авлагын үлдэгдлийг тооцоо нийлээгүй нь дараагийн санхүүгийн дэмжлэг олгох нөхцөл бүрдэхгүй байх үр дагаврыг бий болгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах";, 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтуудыг зөрчсөн байна.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх болон завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана", заалтыг тус тус зөрчсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тус хэлтсийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд авлагын эхний үлдэгдлийг 800.0 мянган төгрөгөөр дутуу, тайлант оны авлагыг 5,561.0 мянган төгрөгөөр, хуримтлагдсан үр дүнг 6,361.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.	3	12,722.0	1	800.0	2	11,922.0	3	12,722.0				
Санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг 312,232.0 мянган төгрөгөөр, зардлын эхний үлдэгдлийг 278,910.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	2	591,142.5			2	591,142.5	2	591,142.5				
Мөнгөн гүйлгээний тайланд эхний үлдэгдлийг 405,474.5 мянган төгрөгөөр, тайлант оны орлогыг 159,087.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, зардлыг 73,958.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	3	638,519.5	2	564,561.5	1	73,958.0	3	638,519.5				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг 634.0 мянган төгрөгөөр, тайлант оны зардлыг 22,398.4 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	2	23,032.4	2	23,032.4			2	23,032.4				
Мөнгөн хөрөнгийн журналд 46,127.5 мянган төгрөгийн ажлын хөлсийг бөөн дүнгээр бүртгэсэн.	1	46,127.5			1	46,127.5	1	46,127.5				
<b>Дүн</b>	<b>11</b>	<b>1,311,543.9</b>	<b>5</b>	<b>588,393.9</b>	<b>6</b>	<b>723,150.0</b>	<b>11</b>	<b>1,311,543.9</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2018-2022 онд олгосон зээлийн эргэн төлөлтийн 26 иргэний 92,475.0 мянган төгрөгийг барагдуулаагүй, авлагын тооцоо нийлээгүй.	1	92,475.0			1	92,475.0						
Өмнөх болон завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.	1	0					1	0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>92,475.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>92,475.0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Шилэн дансны тухай хуульд заасны дагуу мэдээллийг тулгахад 134,193.6 мянган төгрөгийн зарлагын 8 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.	1	134,193.6							1	134,193.6
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>134,193.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>134,193.6</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>